

ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ ТББ

# Илтгэл

**ЦАХИМ ОРЧИНД НЭРЭЭ НУУЦЛАХ ЭРХЭЭ ЭДЛЭХ БОЛОМЖ, ТҮҮНИЙ  
БАТАЛГААЖСАН БАЙДАЛ**

**Илтгэл удирдсан: Л.Галбаатар /Олон улсын эрх зүйч, LLB/**

**Илтгэгчийн нэр: Н.Булгаа /МУИС-ийн Хууль зүйн Сургуулийн Олон Улсын Эрх Зүй-3  
ангийн оюутан, email: nabulгаа@yahoo.com/**

Улаанбаатар  
2014 он

**“Цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломж, түүний баталгаажсан байдал” судалгаа**

АГУУЛГА

Нэг. Удиртгал .....	2
Хоёр. Судалгааны аргазүй, аргачлал .....	5
Гурав. Судалгааны үр дүн.....	7
Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж .....	11
Тав. Ном зүй.....	13
Зургаа. Хавсралт.....	14

## Нэг. УДИРТГАЛ

### Сэдэв сонгох болсон үндэслэл:

Мэдээллийн технологи хөгжихийн хэрээр хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн зан үйл даган өөрчлөгдөж байна. Учир нь хэрэглэгчид уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлээс гадна цахим ертөнцөөр дамжуулан өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, санал бодлоо хуваалцах, зохиох, хэвлэн нийтлэх, мэдээлэл харилцааны бусад сүлжээнд нэвтрэх эрхтэй болж байгаа юм. Энэхүү эрхийнхээ дагуу цахим орчинд нэрээ нууцлах эрхийг эдлэх боломж хэр байдаг талаар түүнийг хууль тогтоомж, хэм хэмжээгээр баталгаажуулсан эсэх нь бидний сонирхлыг ихээхэн татав. Иргэд цахим орчинд ч үг хэлэх эрхээ бүрэн эдэлж, санал бодлоо хуваалцах шаардлагатай байна. Тиймээс цахим ертөнцийн хэрэглэгчдийн эрх ашгийг хүндэлснээр, цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломж олдож байгаа юм.

Цахим орчинд нэрээ нууцлах эрхийг эдлэх боломж, түүнийг баталгаажуулсан эсэхийг судалсан энэхүү бичил судалгаа нь харьцангуй шинэлэг бөгөөд судлаачид хараахан иж бүрэн судалж эхлээгүй талбар мөн гэдэг утгаараа онцлог сэдэв болж байна.

Ардчилсан нийгэмд хүний эрх буюу цөөнхийн үзэл бодлыг дээдэлдэг. Гэвч бодит байдал дээр цөөнх шүүмжлэл, сөрөг байр сууриа илэрхийлсэний улмаас сүрдүүлэг, заналхийлэл хүртэх, амь насанд нь ч аюул учирдаг. Харин Үндсэн хуулиар баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ цахим орчинд эдлэснээр эрх чөлөөтэй байх /улс төр, нийгмийн яриа хэлэлцүүлэгт оролцохдоо нэрээ нууцлахыг хүссэн иргэдийн/ эрх нээгдэж байгаа юм. Энэ нь хуулиар баталгаажсан хүний эрхийг цахим орчинд ч хамгаалахтай холбоотой.

Мөн дээрх сэдэвтэй холбоотой эх сурвалжуудаас дурдвал

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд:

16\итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй.

- Хvний Эрхийн Тvгээмэл Тунхаглалын 19-р зvйлд:

"Хvн бvр өөрийн vзэл бодолтой байж, тvvнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, vvнд vзэл бодлоо ямар ч хориг цээргvй баримтлах, аливаа vзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар vл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, тvгээн дэлгэрvvлэх эрх багтана"

- Иргэний болон Улс төрийн Эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлд:

"Төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр ,түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрхтэй"

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2-р зүйлд:

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно"

Мэдээлэлд хяналт тавихыг хориглох 3-р зүйлд:

3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй.

3.2. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

Олон улсад

- Цахим орчин дахь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал

1948 оны 12 сарын 28-ны НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан. Тэгвэл 50 жилийн дараа уг тунхаглалын өөр нэг хувилбарыг В.Gelman хэмээх судлаач боловсруулжээ.<sup>1</sup> Тунхаглалын 3 дугаар зүйл Хүн бүр орон зайтай байж нэр, онлайн хэлцлээ нууцлах эрхтэй.

- Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ын 3.4 дүгээр зүйлд:

Сэтгэгдэл үлдээхийн тулд нэр /username/ болон имэйл хаягаар логин хийж оруулна.

### **Судалгааны зорилго:**

Хүний эрх нь нийгмийн амьдрал, хүний төрөлх мөн чанар жам ёсны бүх талыг хамардаг учир түүнийг шинжлэн судлах ажил нэн өргөн хүрээтэй, маш олон талтай<sup>2</sup>. “Нэрээ нууцлах эрх” гэдгийг зөвхөн интернэт, цахим, сүлжээ хэрэглэгчдийн хувьд авч үзсэн. Энэхүү илтгэлийн хүрээнд хийсэн судалгаа нь Цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломж, түүний баталгаажсан байдал, интернет хэрэглэгчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж буй эсэх юм.

Монгол улсад нэрээ нууцлах эрхийг хуульчлан тодорхойлж, түүнийг хангах, хамгаалах талаар төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, уг эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах стратегийн зорилт, гол арга хэмжээг тодорхойлоход үндэслэл болохуйц санал зөвлөмж боловсруулахад оршино.

### **Судалгааны зорилт:**

1. Монгол Улсын Үндсэн хууль, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Цахим орчин дахь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Засгийн газрын “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай” 2013 оны нэгдүгээр тогтоол зэрэг холбогдох хууль тогтоомжтой танилцах,

2. Засгийн газрын тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан тогтоол цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломжийг алдагдуулж буй эсэх,

<sup>1</sup> Л.Галбаатар “Цахим эрх зүй” ном 2010 он 12тал

<sup>2</sup> Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” хоёрдугаар боть Хүний эрх ба шүүх эрх мэдэл

2. Тухайн сэдэвтэй холбоотой баримт, мэдээлэл цуглуулах, олон нийт энэ эрхийн талаар хэрхэн мэдэж буйг судлах,
3. Цахим хуудас болон түүнтэй холбоотой дүрэм журам мөрдөн ажилладаг байгууллага болон мэргэжилтнүүдтэй уулзаж, зөвлөгөө авах,
4. Интернет тогтмол хэрэглэгчдийн дунд анкетын аргаар судалгаа авах,
5. Мөн сэтгүүлчдийн хувьд нэрээ нууцлах эрх нь зөрчигддөг гэдгийг гаргаж ирэхэд оршино.

### **Судалгааны таамаглал:**

1. Цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломжгүй байна, үүний нэг гол шалтгаан нь Засгийн Газрын 2013 оны нэгдүгээр тогтоолтой холбоотойгоор холбогдох байгууллагуудаар дамжуулан хяналтын систем үүссэн явдал мөн.
2. Цахим орчинд нэвтэрч буй хүмүүсийн дийлэнх нь хуулийн мэдлэг бага байна. Цахим орчин дахь тухайн хүний гэрэл зураг, дуу, дүрс, хувийн мэдээлэл зэргийг зөвшөөрөлгүйгээр ашиглан, бусдын эрх, нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдах нь олон тохиолдож байна
3. Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хууль байхгүй. Цахим орчинд нэрээ нууцлан, улс төр болон нийгмийн хэлэлцүүлэгт үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй хэмээн баталгаажуулсан нь үгүй.
4. Цахим ертөнцийг ямар ч хяналтгүй талбар гэж ойлгодог. Дийлэнх хүн техникээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлж байгаа учраас өөртөө хяналтгүй ханддаг. Жишээ нь үзэл бодлоо хараалын үгээр илэрхийлэх, доромжлох, гүтгэх гэх мэт.

### **Хоёр. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ:**

Судалгааны ажилдаа Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал”<sup>3</sup> номын хоёрдугаар боть, Тавдугаар бүлэг, “Хүний эрхийн зөрчлийг судлах аргачлал”-ыг баримтласан болно. Мөн мэдээллийг бүрдүүлэхдээ анкетын болон ярилцлагын аргыг ашиглаж, боловсруулалтыг тоон үр дүнг боловсруулах excel програм ашиглан анализ хийлээ.

Тоон судалгаандаа санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашиглав. Судалгаанд “Өглөөний сонин”, “Зууны мэдээ”, “ТВ 9” телевиз, “SBN” телевиз, “TV5” телевиз, “TIME.MN” сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг сэтгүүлчид хамрагдсан болно.

### **Судалгааны асуулт:**

Судалгаанд хамрагдсан иргэд цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломжоо ашиглаж чадахгүй байгаа шалтгаан, түүнийг хэрхэн баталгаажуулж болохыг тодорхойлох зорилгоор дараах асуултыг ашигласан юм.

1. Интернетэд үзэл бодлоо илэрхийлэхэд та өөртөө хяналт тавьдаг уу?

---

<sup>3</sup> Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” хоёрдугаар боть 2004 он

2. Цахим орчин дахь улс төр, нийгмийн хэлэлцүүлэгт нэрээ нууцлах шаардлагатай юу?
3. Цахим орчин дахь улс төр, нийгмийн хэлэлцүүлэг болон бусад харилцаанд нэрээ нууцлах хэрэгцээ гардаг уу?
4. Цахим орчин дахь улс төр, нийгмийн хэлэлцүүлэгт нэрээ нууцлахаас та эмээдэг үү?
5. Нэрээ нууцласан үедээ чөлөөтэй харилцаа үүсгэж чаддаг уу?


### Туршилтын судалгаа

Асуултын чанар, логик уялдаа, хариултын боломжит хувилбар, судалгаанд оролцогчдын сэтгэлзүйн байдлыг тандах зорилгоор туршилтын судалгааг Монгол Улсын их сургуулийн 60 оюутны дунд хийж үзсэн. Судалгаанд оролцсон оюутнуудын хариулт судалгааны зорилгод нийцээгүй учир бүтээлдээ дурдаагүй болно.

### Гурав. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Судалгаанд оролцсон сэтгүүлчдээс “Цахим орчинд нэрээ нууцлах эрхээ эдлэх боломж, түүний баталгаажсан байдал” сэдвийн талаарх асуултад хариулсан байдлыг графикаар харуулж байна.

*График-1: Судалгаанд оролцогчдын 68% нь ихэнхдээ буюу заримдаа үзэл бодлоо илэрхийлэхдээ өөртөө хяналт тавьдаг байна.*




Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 34% буюу 10 нь интернэтэд үзэл бодлоо илэрхийлэхдээ ихэнхдээ өөртөө хяналт тавьдаг гэсэн. Харин 34% буюу 10 нь заримдаа гэж хариулсан. Мөн зургаан хүн буюу 20% нь огт үгүй гэсэн, 12% буюу дөрөв нь үргэлж гэж хариулсан сэтгүүлч байлаа.

*График-2: Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 40% нь цахим орчинд нэрээ нууцлах хэрэгцээ гардаггүй. Харин 37% заримдаа хэрэгцээ гардаг гэв.*




Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдээс 40% буюу 12 нь нэрээ нууцлах хэрэгцээ гардаггүй, 37% буюу 11 нь нэрээ нууцлах хэрэгцээ заримдаа гардаг гэсэн. Харин ихэнхдээ ;дөрөв буюу 13%, үргэлж нэрээ нууцлах хэрэгцээ гардаг хэмээн гурав буюу 10% нь хариулсан байлаа.

*График-3: Цахим орчин дахь улс төр, нийгмийн хэлэлцүүлэгт нэрээ нууцлахаас огт эмээдэггүй гэж 63% нь хариулав.*



Үүнээс харахад цахим орчинд нэрээ нууцлахаас 63% буюу 19 сэтгүүлч эмээдэггүй гэсэн бол 34% буюу 10 нь заримдаа эмээдэг гэв. Харин 3% буюу нэг сэтгүүлч үргэлж эмээдэг гэжээ.

*График-4: Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 40% нь нэрээ нууцалсан үедээ чөлөөтэй харилцаа үүсгэж чаддаг. Мөн 30% ихэнхдээ гэж хариулсан байна.*



Үүнээс харахад сэтгүүлчид нэрээ нууцалсан үедээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг гэж 40% буюу 12 нь хариулсан бол 30% буюу ес нь ихэнхдээ гэсэн байна. Харин 20% буюу заримдаа гэж зургаан сэтгүүлч, 10% буюу гурав сэтгүүлч огт үгүй хариулсан юм.

*График-5: Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 53% нь заримдаа нэрээ нууцлах шаардлага гардаг гэсэн.*



*Сэтгүүлчдийн 53% буюу 16 нь заримдаа нэрээ нууцлах шаардлага гардаг гэсэн бол 27% буюу найм нь шаардлагагүй гэжээ. Харин ихэнхдээ гэж 13% буюу дөрөв нь үзсэн бөгөөд 7% буюу хоёр нь үргэлж нэрээ нууцлах шаардлагатай гэжээ.*

### **Дөрөв. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

1. Судалгаанд оролцогчдын 68% нь ихэнхдээ буюу заримдаа үзэл бодлоо илэрхийлэхдээ өөртөө хяналт тавьдаг байна. Мөн Харилцаа холбооны зохицуулах

хороонд бүртгүүлсэн вэб сайтуудад хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараах зохицуулалтыг дагаж мөрдөнө гэж заажээ. Үүнд:

-Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программ

[www.happywebs.mn](http://www.happywebs.mn) заавал ашиглах

-Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлчилгээг ашиглахыг сануулсан нөхцөл шаардлагыг зөвшөөрсөн хэрэглэгчийн контент үүсгэх боломжоор хангах,

-Хэрэглэгч аль нэг өөр хэрэглэгчийн үүсгэсэн контентыг хууль бус, нийтийн ёс зүйд сөрөг нөлөөтэй гэж үзвэл саналаа илэрхийлэх, саналын тооноос хамаарч тухайн контентыг арилгах боломжийг бүрдүүлэх

-Хэрэглэгчийн интернэт хаягийг хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах зэрэг шаардлагыг зөрчсөн тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хорооноос холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авдаг байна. Энэ нь иргэдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулж, өөртөө хяналт тавих сэдлийг бий болгодог.

*Төрөөс тодорхойлсон зорилго нь зөв хэдий ч хэрэгжүүлж буй арга хэрэгсэл нь хүний эрхийг зөрчиж байна. Тиймээс цахим орчинд ч хүний эрхийг хамгаалж, баталгаажуулах нь зүйтэй.*

2. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 40% нь цахим орчинд нэрээ нууцлах хэрэгцээ гардаггүй гэсэн. Дээр дурдсанчлан Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан журмын дагуу хэрэглэгч сэтгэгдлээ үлдээх шаардлагатай учраас вэб сайтуудад сэтгэгдлээ бичихийг хүсдэггүй гэв. Мөн сэтгүүлчдийн өдөр тутмын ажлын ачаалал, цагийн дарамттай тулгардаг тул нэрээ нууцалж үзэл бодлоо илэрхийлэх боломжгүй байдаг.

*Цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зайг үүсгэх хэрэгтэй*

3. Цахим орчин дахь улс төр, нийгмийн хэлэлцүүлэгт нэрээ нууцлахаас огт эмээдэггүй гэж 63% нь хариулав. Интернэт хэрэглэгчид сэтгэгдэл бичиж, үзэл бодлоо илэрхийлэхдээ хэн нэгэн үүнийг хянадаг гэдгийг мэддэггүй. Цахим ертөнцийг ямар ч хяналтгүй талбар гэж ойлгодог. Дийлэнх хүн техникээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлж байгаа учраас өөртөө хяналтгүй ханддаг. Жишээ нь үзэл бодлоо хараалын үгээр илэрхийлэх, доромжлох, гүтгэх гэх мэт.

*Цахим орчинд нэвтэрч буй хэрэглэгчийг соёлтой, зөв боловсон үзэл бодлоо илэрхийлэх хандлагад уриалах нь зүйтэй.*

4. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 40% нь нэрээ нууцалсан үедээ чөлөөтэй харилцаа үүсгэж чаддаг гэжээ. Үүнээс харахад цахим орчны хэрэглэгчдэд эрх чөлөө, үгээ илэрхийлэх боломж бага байдгийг харуулж байгаа юм. Нэгэн жишээ дурдахад НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /OSCE/ -ын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгч болон Америкийн муж улсуудын байгууллага \OAS\ -ын үзэл бодлын эрх чөлөөний тусгай илтгэгч нарын 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Хамтарсан

тунхаглалд “Интернэт үйлчилгээний нийлүүлэлт, цахим хуудас, блог буюу мэдээлэл түгээлтийн онлайн систем, түүнчлэн интернэт өргөн нэвтрүүлэг ажиллуулахын тулд бүртгүүлэх, төрийн аливаа байгууллагаас зөвшөөрөл авах ёсгүй. Энэ нь зөвхөн техникийн зориулалтаар домэйн нэрийн эрхийн бүртгэл, эсвэл арилжааны аливаа хэлбэрт хамааралтай ерөнхий хэрэглээний дүрэм журамд хамаарахгүй” гэсэн байдаг. Төр аман дээрээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хайртай хэмээн зарладаг боловч ажил хэрэг дээр өөрийн эрх мэдэлд харшлагч үг ярианд хичнээн хойрго хандаж байгааг дээрх үйлдлүүд нь харуулж байна.

*Төрийн хяналтыг үгүй болгож, цахим орчинд ч иргэдийнхээ дуу хоолойг сонсох нь чухал.*

5. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 53% нь заримдаа цахим орчинд нэрээ нууцлах шаардлага гардаг гэсэн. Гэвч Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ын 3.4 дүгээр зүйлд:

Сэтгэгдэл үлдээхийн тулд нэр /username/ болон имэйл хаягаар логин хийж оруулна гэжээ. Энэ нь тухайн хүний \IP\ хаягийг нь мэдэх боломжийг бүрдүүлдэг. Шаардлагатай тохиолдолд цахим орчинд нэрээ нууцлан, үзэл бодлоо илэрхийлж байгаа иргэнийг хамгаалах баталгаагүй болж байна. Үүнээс харахад нэрээ нууцлах эрхээ эдлэх боломж харагдахгүй байна.

*Тиймээс цахим орчинд сэтгэгдэл үлдээхдээ иргэдийн хувийн мэдээллийг ашиглахгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх орчинг бүрдүүлэх хэрэгтэй.*

### **Тав. НОМ ЗҮЙ**

1. “Цахим эрх зүй” УБ. 2010 он Л.Галбаатар
  2. “Үндсэн хуулийн үзэл баримтлал” хоёрдугаар боть УБ. 2004 он Б.Чимид
  4. “Либертарианизм” Давид Боаз монсудар 2005 он 120 талаас
  5. Интернэтийн эрх зүй глобаль зохицуулалт /илтгэл/, Боннын Т.Алтангэрэл
  3. Глоб интернэшнл төв ТББ <http://www.globeinter.org.mn/>
- Иргэний мэдэх эрх /иргэдэд зориулсан гарын авлага/  
Гүтгэлэг, доромжлол гэмт хэрэг мөн үү? 2008 он, ГИТ  
Мэдээллийн нууц эх сурвалж, 2006, ГИТ  
Мэдээллийн эрх чөлөө, гарын авлагууд, ГИТ

### **Зургаа. ХАВСРАЛТ**

- “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем” Засгийн газрын 2013 оны 1-р тогтоол <http://www.legalinfo.mn/law/details/8939?lawed=8939> линк рүү орно уу.

- Хориотой үгсийн хяналтын сайт <http://www.happywebs.mn/>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- Кибер аюулгүй байдлын газар: [www.ncsc.gov.mn](http://www.ncsc.gov.mn)
- Цахим эрх зүй блог– [galbaatar.blogspot.com](http://galbaatar.blogspot.com)
- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар: [www.itpta.gov.mn](http://www.itpta.gov.mn)
- Харилцаа холбооны зохицуулах хороо: [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn)
- Төрийн байгууллагуудын вэб сайт: [www.pmis.gov.mn](http://www.pmis.gov.mn)